



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

15150-0007 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5 дугаар хороо, Тасганы овоо, Хувьсгалын зам 22,
Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн байр,
Утас: 7000 8045, Факс: (976) 7000 7021,
И-мэйл: contact@judcouncil.mn, Вэбсайт: www.judcouncil.mn

2020.05.20 № 01/583
танай _____-ны № _____-т

Улсын дээд шүүхийн шүүгчийн
албан тушаалд нэр дэвшигчийг
танилцуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн нэр дэвшигч Сүхдоржийн Батхүлэг, Цэндийн Цогт нарыг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилуулах тухай саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэснийг хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна уу.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол, нийт ... хуудас баримт бичгийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Э.БАТБАЯР

011400986



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 39


Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг Улсын дээд шүүхийн
шүүгчийн албан тушаалд томилуулах тухай
саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид
өргөн мэдүүлэх тухай

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, Шүүхийн захиргааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

Сүхдоржийн Батхүлэг, Цэндийн Цогт нарыг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилох тухай саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

ДАРГА



Э.БАТБАЯР

011000313